

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	М.Доржнамжим	Дугаар	L075
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Гурванзагал
Төрсөн газар	Дорнод аймгийн Гурванзагал	Төрсөн он	1929
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дэчин гэгээний хийд, Данригданжаалин хийд	Сүм хийдийн дугаар	ДОЧБ 037, ДОЧХ 010
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Чойбалсан сумын Дэчин гэгээний хийд Хэрлэн сумын Данригданжаалин хийд

-Танай нутаг оронд ямар ямар хурлын газар байв?

Айраг гэж эндээс 30 гаруй км-т урагшаа харсан сархиаг бий. Тэнд нэг хурлын газар байсан. Хамгийн сүүлчийнх нь юм даа. Тэнд нэг наадамд. Даага унаж байсан юм. Тэр хийдийн хамгийн сүүлийн наадам байсан байна.

Тэгэхээр тэр хийд бол уг нь Өлзий зангийн сум гэж байсан юм. Тэндээс Дэлгэрмөнх, Баян-Эрхт, Хөгнөө тахидаг байсан. Манайх чинь хуучин Очирбаянмөнх сум байсан. Тэгээд би 1938, 39 оны үед наадамд даага унаад түрүүлж байлаа. Намар оройхон л байсан. Тэгээд тахичихаад бөхөө барилдуулж, даага уралдуулж номоо уншина.

-Бид нэг судалгаа бүртгэлтэй яваа. Тэрэн дээр Баян-Эрхт нуурын хурал мөн Өлзий зангийн хийд гэж ярьдаг байсан юм үү даа. Сан бэйсийн хошуу хүрээ Өлзий зангийн хийд гэж тэмдэглэгдсэн байна.

Хуучин Хөгнө Чойбалсан сумтай нийлж наадмаа хийгээд уулаа тахидаг байсан. Өлзий зангийн сум гэдэг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тэр маань бас нэг хурал байгаа ш тээ?

Цагаан нуурын дэргэд байгаа. Тэрний дэргэд хүүхдийн овоо гэж байгаа.

-Тэр хурлыг Баяндун хурал гэж байсан уу?

Тийм. Баяндун гэдэг овоогоо тахидаг юм. Баяндунгийн баруун урд талдаа. Хүүхдийн овооны дэргэд нь овоо байгаа. Нэг нь гал тогоо хоол цайгаа хийнэ. Нэг нь хурлынх. Тэрний ч одоо суурь нь байгаа.

-Өөр одоо ямар хурлын газар байсан бэ? Дэлгэрмөнхөд хийд байсан уу?

Дэлгэрмөнхөд хийд байгаагүй. Дэлгэрмөнх гэдгийг хамгийн түрүүн Хан уулын дараагаар Сан бэйсийн хошууны Өлзий зангийн сум тахидаг байсан.

-Өөр энэ Гурванзагал сумд хамаарах ямар ямар хийд, хурлын газар байсан юм бэ?

Нуурын баруун хойно нэг суурь байдаг юм. Тэр одоо тэдээс тэдэн онд байсан гэх сураг алга. Манай ээжийн эцэг Нэмэхийн Намсрай гэдэг хүн 1949 онд 80 гарсан хойноо нас барсан. Байхдаа тийм хурал төдийд өдийд байсан гэдгийг яриагүй. Тэгэхээр энэ бол нэлээд дээхнэ үрэгдсэн байх.

-Тэр нь болохоор Сүмийн нуур гэдэг үү?

Сүм гэдгийнхээ хойд талд нь сүм нь урд талд нь нуур байгаа.

-Тэр бол нэг хийд байсан гэж үү?

Байсан. Байсан. Зүгээр би дам сураг дуулах нь бол Буриадын зохиолч Намсрайевын “Нойрноос сэрсэн тал” гэдэг ном байдаг шүү дээ. Тэнд Тавхай Дугар гэж Цагаан хааны үед буриад талыг захирч явсан цэргийн дарга. Тэр хүний үед л үрэгдсэн юм болов уу гэж ярьдаг юм. Тэр нь бол одоо 1920-оод оны үед юмуу. Хойноос цагаантнууд Монголд орж ирсэн тэр үед л болов уу гэж ярьдаг байсныг би сонсож байсан юм. Хөх тоосгон барилга байсан юм билээ. Ганц дугантай. Зүүн талдаа нэг жижигхэн байшингийн суурь байдаг юм.

-Өөр ямар хийд байв?

Өшөө хурлын газар бол энд байгаагүй. Ламын хийд гэдгээр явсан уу?

-Явсан.

Хоёр хийд байсан юм. Нэг нь баруун дээр нь. Нэг нь дор нь.

-Та тэр Мээрэнгийн хурал гэж мэдэх үү? Баяндунгаас жаахан урагшлаад байсан юм уу даа?

Мээрэнгийн суурин гэж байснаас Мээрэнгийн хурал гэж байгаагүй. Тэнд худалдаачин хятадууд байсан гэдэг юм. 1921 оны үед дайнаас дажин гэгчээр хажуугаар нь бас хүмсүүд тэднийг дээрэмдээд зарим нь явж зарим нь үрэгдсэн. Тэгээд тэрний чинь ямар Мэйрэн гэлээ. Аа тийм Дугар Мэйрэн гэж байсан гэсэн. Мээрэнгийн суурин гэдэг чинь Дэлгэрмөнх гэдэг уулын баруун урдхантаа.

-Энгэр шанданд биз дээ?

Одоо тэрний суурь байхгүй. Тэнд чинь айл өвөлждөг байсан юм. Чулууг нь аваад. Сүүлдээ тэгээд байхгүй болоо шүү дээ.

-Баруун тийшээгээ Баянтүмэний нутаг руу бараг орчих болов уу? Тэнд нэг хоёр хийд байсан байна. Хүйн хурал, Юмын хурал гээд? Танд энэ тухай сонссон дуулсан зүйл байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Би баруун талаар бол мэдэхгүй.

-Баян-Эрхтийн Айргийн хурал маань хэр олон ламтай ямархуу хурлын газар байсан бэ? Ямар сахиустай байсан бол?

За цөөхөн ламтай газар байсан байх аа. Манай энд чинь лам гэдэг улсууд чинь миний багад чинь лам гэхээр Чойдог маарамба гэж байсан юм. Даваа гэдэг хүн байсан. Осоржамц, Баднаасамбуу гэж хүн байсан юм.

-Ер багцаагаар хэд орчим ламтай байсан бэ?

Ёстой мэдэхгүй байна. Ер нь олон хүн баригдсан. Ээж аав хоёрын ярьж байсныг анхаардаггүй л байж дээ. Тийм л үе байж.

-Хамгийн сүүлийн наадам хийдэг маань хэдэн он бэ? Таны даага унаж уралддаж байхад хуралтай байсан уу? 1938,39 оны үе. Тэр үед хуралтай байсан. Ер тэгээд л хэлмэгдүүлэлт эхэлсэн шүү.

-Баян-Эрхтийн Айргийн хурал маань ямар сахиустай байсан бэ?

Бүү мэд. Нэг алтан түрхэцтэй том бурхан байдаг л байсан.

-Дуган нь юугаар баригдсан байсан бол?

Чулуун дуган байсан.

-Хэдэн оны үед байгуулагдсан юм бол?

Ёстой мэдэх юм байхгүй. Эртнийх л байх.

-Хийдийн жасын мал хөрөнгийн хувьд?

Ер нь айл хунараас л авч байсан байх даа.

-Ямар ямар хуралтай байсан бол? Майдар эргэх, Ганжуур эргэх ч юм уу?

Миний мэдэхээс л хойшоо овоо руугаа явж тахидаг байсан.

-Өдөр тутам хурдаг байсан уу? Цагийн хуралтай байсан болов уу?

Цагийн. Ерөөсөө намар орой л нэг цуглаж хурдаг байсан. Ардуудаас цагаан идээ цугладаг байсан. Жилдээ ганцхан удаа намар л хурдаг байсан.

-Хийдийн мяндагтан лам нарыг хэн хэн гэдэг байсан бэ?

Ёстой мэдэхгүй. Гарваан багш л гэж улсууд их ярьдаг байсан. Гарваан багш, Гарваан лам гэж.

-Хийдийг хэдэн онд нураасан бэ? Хийд хаагдах болсон шалтгаан нь юу вэ?

Оросууд л нурааж байна гэж дуулдаж байсан. Бариа тавиа эхэлсэн. Тэгээд байхгүй болсон биз дээ.

-Хийдийн барилгыг юунд ашигласан юм бол? Бурхан шүтээнээс нь авч үлдсэн юм байдаг болов уу?

Байхгүй ээ. Бурхан тахил ном судрыг бүгдийг нь шатаачихсан. Бурхан нь ер нь том бурхан байсан шүү.